



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 684

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1 Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/14008 дугаар албан бичиг болон Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 1/3986 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлаар Лочингалсангийн Батжаргалыг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ